*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

*Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга*
*/ албан тушаалын нэр /*
Б.Нямдаваа
*/ албан хаагчийн нэр /* -ний
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН БУЮУ НЭГЖИЙН ДАРГА)

Байгууллагын нэр: .Зам, тээврийн хөгжлийн яам

Нэгжийн нэр: Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээ 1.1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны гадаад нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах. | 100 | 70 |
| 2 | Арга хэмжээ 1.2. Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны нэгжүүдийн дунд сургалт, семинар зохион байгуулах. | 100 | 70 |
| 3 | Арга хэмжээ 1.3. Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн гадаад айлчлалаар хэлэлцэх асуудалд салбарын чиглэлээр санал хүргүүлж тусгуулах. | 100 | 70 |
| 4 | Арга хэмжээ 1.4. Зам, тээврийн хөгжлийн сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын гадаад орнуудад хийх айлчлалын бэлтгэл хангах, албан хаагчид, харьяа байгууллагын удирдлагуудын гадаадад томилолтоор ажиллахтай холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зохион байгуулах. | 100 | 70 |
| 5 | Арга хэмжээ 1.5. Зам, тээврийн хөгжлийн сайдын БНХАУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэх хангах, зохион байгуулах. | 100 | 70 |
| 6 | Арга хэмжээ 1.6. ХБНГУ-ын Цахим хөгжил, тээврийн сайд Фолкер Виссингийн Монгол Улсад хийх айлчлалын бэлтгэл хангах, зохион байгуулах. | 100 | 70 |
| 7 | Арга хэмжээ 1.7. Зам, тээврийн хөгжлийн сайдын БНСВУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэх хангах, зохион байгуулах | 86,5 | 60,6 |
| 8 | Арга хэмжээ 1.8. Зам, тээврийн хөгжлийн сайдын Европын холбооны | | |

| | | | |
|---|---|---|---|
| | улсад хийх ажлын айлчлалын бэлтгэх хангах, зохион байгуулах. | | |
| 9 | Арга хэмжээ 1.9. Монгол Улсын Засгийн газар, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах | 100 | 70 |
| 10 | Арга хэмжээ 1.10. Монгол Улсын Засгийн газар, Австралийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээр үзэглэх чиглэлээр ажиллах | 42,8 | 30 |
| 11 | Арга хэмжээ 1.11 Бүгд Найрамдах Узбекистан Улстай Олон улсын автотээврийн тухай болон агаарын харилцааны хэлэлцээр байгуулах Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах | 100 | 70 |
| 12 | Арга хэмжээ 1.12. Гадаад улстай хийх Засгийн газар хоорондын комиссын хуралдаан, олон улсын хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зэрэг хамтын ажиллагааны уулзалтуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах. | 100 | 70 |
| 13 | Арга хэмжээ 1.13. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын хурал | 85,7 | 60 |
| 14 | Арга хэмжээ 1.14. Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Тээврийн ажлын хэсгийн хурал зохион байгуулах. | 100 | 70 |
| 15 | Арга хэмжээ 4.2.1. Гадаад улс, олон улсын байгууллагуудтай хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр болон бусад баримт бичгийг байгуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах. | 100 | 70 |
| 16 | Арга хэмжээ 2.1. Салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнг нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд түгээх | 92,8 | 65 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. | 100 | 15 |
| Монгол бичгийн анхан шатны сургалтад сууж, амжилттай шалгалт өгсөн | | | **15** |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Удирдан зохион байгуулах | |

| | | |
|---|---|---|
| 3. | Асуудал шийдвэрлэх | |
| 4. | Манлайлах | |
| 5. | Багаар ажиллах | |
| 6. | Харилцаа | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | **13** |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | **67.9** |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | ~~**15**~~ 7.0 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 13 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | 88 |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 88. |

*Үнэлгээ өгсөн:* *Нэгжийн дарга:*

........................................ ................................ /................................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.06 ................................ *(огноо)*

*Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:* *Нэгжийн дарга:*

........................................ ................................ /................................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.06 ........................ *(огноо)*

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

Улаанбаатар хот

| № | Зорилтын арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтод түвшин | Биелэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **САЛБАРЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.** | | | **Зохион байгуулсан арга хэмжээний тоо** | **2023 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан.** | **Зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | **Биелэлт** | |
| **Зорилт 1. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжүүлэх, үйл ажиллагааг нь зохицуулах;** | | | | | | | |
| 1.1. Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулна. | | | | | | | |
| 1.1.1 | Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны гадаад нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах. | - | Хэрэгжилтийн хувь | 2023 оны гадаад, арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, 95% хэрэгжүүлсэн. | **I-II улирал:** 2024 оны гадаад арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, төлөвлөгөөний хэрэгжилт 40-өөс доошгүй хувь байна. **III-IV улирал:** Төлөвлөгөөний хэрэгжилт **95 хувиас** доошгүй байна. | -Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны Гадаад арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд яамны газар, хэлтсүүдээс санал авч удирдлагуудад танилцуулан ТНБД-аар 2024.01.29-ний өдөр батлуулж хэрэгжилтийг хангуулахаар хувийг нийт албан хаагчдад хүргүүлж мэдээлсэн.<br>Энэ оны Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга болон гадаадын өндөр дээд хэмжээний айлчлал 8, ЗГХК-ын хуралдаан, зөвлөгөөн, уулзалт 4, Монгол Улсад зохион байгуулагдах хурал, зөвлөгөөн, уулзалт, семинар 12, гадаадад зохион байгуулагдах хурал, зөвлөгөөн, уулзалт, семинар 25, сургалт, туршлага судлах танилцах аялал 8 тус тус тусгагдсан болно.<br><br>Гадаад арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын байдлаар:<br>-ЗТХ-ийн сайдын болон ТНБД-ийн нийт 15 айлчлал зохион байгуулсан. /Сайдын 9 айлчлал, ТНБД-ын 6 айлчлал/<br>-Гадаад улсаас Монгол Улсад 2 айлчлал /ХБНГУ-ын тээврийн сайдын Монгол улсад хийсэн ажлын айлчлал, БНХАУ-ын Ляонин мужийн дэд захирагч Жин Гуо Вэй-ийн Монгол Улсад хийсэн ажлын айлчлал/-ыг тус тус амжилттай зохион байгуулсан байна. | |

148

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -ЗГХК-ын хуралдаан, зөвлөгөөн, уулзалт 4, Монгол Улсад зохион байгулагдсан хурал зөвлөгөөн 12,<br>-Гадаад улсад зохион байгуулагдах хурал, зөвлөгөөн-48 удаа 93 хүн, сургалт семинарт, туршлага судлах аялалд-24 удаа-55 хүн, нийт давхардсан тоогоор нийт 148 яамны албан тушаалтан, албан хаагч, харьяа байгууллагуудын удирдлагуудыг хамруулсан байна. | |
| 1.1.2 | Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны нэгжүүдийн дунд сургалт, семинар зохион байгуулах. | - | Хэрэгжилтийн хувь | 2023 оны Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан. | **I-II улирал:**<br>Зөвлөгөөн хийх хугацаар яамны удирдлагуудтай зөвлөж товлосон байна.<br>Зөвлөгөөний хөтөлбөрийг боловсруулсан байна.<br>Зөвлөгөөнд оролцох урилгыг харьяа байгууллагуудад хүргүүлсэн байна.<br>Зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. | Монгол Улсын зам, тээврийн салбарт хэрэгжүүлж буй гадаад харилцаа, хамтын ажиллагаанд нэгдмэл бодлого чиглэл баримтлах, гадаад арга хэмжээний үйл ажиллагааг харилцан уялдаатай төлөвлөх, нэгдсэн зохион байгуулалтаар хангах зорилгоор "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчид болон харьяа байгууллагуудын гадаад харилцааны асуудал хариуцсан албан хаагчдын сургалт, семинар"-ыг 2024 оны 05 сарын 07-ны өдрийн 08.30-11.30 цаг хүртэл Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоот хурлын зааланд зохион байгуулав.<br><br>Сургалтанд Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газрын дэд захирал Г.Батбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны ТНБД С.Батболд, БТГ-ын дарга Б.Болор-эрдэнэ, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн 4 албан хаагч, харьяа 8 байгууллагын гадаад хамтын ажиллагаа хариуцсан 20 албан хаагч биетээр оролцсон ба цахимаар/Zoom/ мэдээлэл дамжуулж ЗТХЯ-ны бусад газар, хэлтсийн 30 гаруй албан хаагчдыг хамруулж, мэдээлэл өгөв.<br><br>Сургалтаар зам, тээврийн салбарт хэрэгжүүлж буй гадаад харилцаа, хамтын ажиллагаанд нэгдмэл бодлого чиглэл баримтлах, бодлого чиглэлийг хэрхэн уялдуулах талаар болон дипломат ёслол, гадаад хамтын ажиллагаанд баримтлан ажиллах ёс зүй, гадаадад болон дотоодод арга хэмжээ хэрхэн зохион байгуулах, анхаарах асуудлын талаар харилцан мэдээлэл авч, харилцан туршлага солилцож, хэлэлцүүлэг өрнүүлсэн ажил хэрэг сургалт болсон. | |
| 1.1.3 | Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн гадаад айлчлалаар хэлэлцэх асуудалд салбарын | - | Айлчлалаар хэлэлцэх асуудалд тусгасан саналын тоо | Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн 16 | **I-IV улирал:**<br>Айлчлалын удирдамж, уулзалтын ярианы сэдэвт салбарын чиглэлээр санал | <u>Монгол Улсаас гадаад улсад:</u><br>Оросын Холбооны Улсад, Бүгд найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улс, Бүгд | |

149

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр санал хүргүүлж тусгуулах. | | | айлчлалд санал хүргүүлсэн. | тусгагдсан байна. /тухай бүр/ | найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Туркменистан Улс, Бүгд Найрамдах Франц тэргүүнүүдтэй хийх уулзалт,<br><br><u>Гадаад улсаас Монгол Улсад</u>:<br>Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улсаас, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Бүгд Найрамдах Филиппин, Бүгд Найрамдах Казахстан Улс, БНСВУ, БНХАУ, Бүгд Найрамдах Словени Улс, ОХУ, Бутаны Хаант Улс, Швейцарийн холбооны Улс, Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад тус тус албан ёсны айлчлал хийхтэй холбогдуулан монголын талаас баримтлах яриа хэлэлцээний сэдэвт зам, тээврийн салбарын чиглэлээр тусгах саналыг боловсруулж ГХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал өгөх, эдгээр төлөвлөгөөнүүдийн биелэлтийн талаарх мэдээллүүдийг нэгтгэн ГХЯ-нд тус тус хүргүүлсэн.<br><br>2024 оны 12 дугаар сарын байдлаар Төр, засгийн тэргүүн, өндөр дээд түвшний төлөөлөгчдийн Монгол Улсад, Гадаад улс руу харилцан хийсэн <u>***нийт 40***</u> <u>албан ёсны айлчлалаар хэлэлцэх асуудалд салбарын чиглэлээр санал хүргүүлж тусгуулсан</u>. Үүнд:<br>1.Монгол Улсын Ерөнхий сайдын ХБНГУ-ын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэртэй 2024.02.08-ны өдөр хийх уулзалтын ярианы сэдэвт,<br>2.Монгол Улсын Их хурлын дарга Г.Занданшатарын Унгар улсад хийх айлчлалын үеэр хийх уулзалт ярианы сэдэвт,<br>3. Монгол Улс, Бүгд Найрамдах Словени Улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд 2024 онд зохион байгуулахаар төлөвлөж буй өндөр дээд хэмжээний айлчлалын үеэр Бүгд Найрамдах Словени Улстай байгуулах баримт бичгийн талаар санал,<br>4. Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд 2024 онд зохион байгуулахаар төлөвлөж буй өндөр дээд хэмжээний айлчлалын үеэр Бүгд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Найрамдах Турк Улстай байгуулах баримт бичгийн талаар санал,<br>5.Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны VIII хуралдааныг 2024 оны 03 дугаар сард Сөүл хотноо зохион байгуулахаар төлөвлөж байгаатай холбогдуулан хуралдааны удирдамж, протоколын төсөлд санал тусгуулсан.<br>6.Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд хийгдэхээр төлөвлөгдөж буй айлчлалын үеэр монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>7.Монгол Улсаас 2024 онд Бүгд Найрамдах Узбекистан Улсад дээд түвшний айлчлал хийхээр төлөвлөж байгаатай холбогдуулан уг айлчлалын үеэр хийх яриа хэлэлцээний сэдэвт,<br>8.Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүгд Найрамдах Киргиз Улсын Жогорку Кенеш-ийн дарга Н.Шакиевийн урилгаар 2024 оны 02 дугаар сард тус улсад албан ёсны айлчлал хийх гэж байгаатай холбогдуулан яриа хэлэлцээний сэдэвт,<br>9.Бүгд Найрамдах Беларусь Улсын Гадаад хэргийн сайд С.Ф.Алейник 2024 оны 03 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийх гэж байгаатай холбогдуулан монголын талын баримтлах ажлын удирдамжийн төсөл болон яриа хэлэлцээний сэдэвт,<br>10.Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгаар Бүгд Найрамдах Киргиз Улсын Парламент Жогорку Кенеш-ийн дарга Н.Шакиев 2024 оны 04 дүгээр сард Монгол Улсад албан ёсны айлчилж, "Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ" II чуулга уулзалтад оролцохоор төлөвлөж байгаатай холбогдуулан яриа хэлэлцээний сэдэвт,<br>11.Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч А.Г.Лукашенко 2024 оны 05 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийх гэж байгаатай холбогдуулан монголын талын яриа хэлэлцээний сэдэвт,<br>12.Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2024 оны 06 дугаар сард Бүгд Найрамдах Узбекистан Улсад төрийн айлчлал хийхээр төлөвлөж байгаатай холбогдуулан уг айлчлалын үеэр хийх яриа хэлэлцээний сэдэвт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 13. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2024 оны 07 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотноо зохион байгуулагдах Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд оролцож, энэ үеэр Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн тэргүүн нартай гурван талт уулзалт хийх гэж байгаатай холбогдуулан уулзалтын ярианы сэдэвт,<br>14.Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улсаас 2024 оны 06 дугаар сард Монгол улсад дээд түвшний айлчлал хийхээр төлөвлөж буйтай холбогдуулан Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>15.Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Ерөнхий захирал Чу Донгиу 2024 оны 07 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Монгол Улсад хийх албан ёсны айлчлалын үеэр хийх ярианы сэдэвт,<br>16.Бутаны Хаант Улсаас 2024 оны 07 дугаар сард Монгол Улсад дээд түвшний айлчлал хийхээр төлөвлөж буйтай холбогдуулан Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>17.Бүгд Найрамдах Филиппин Улсын Гадаад хэргийн сайд Энрикэ А.Манало 2024 оны 08 дугаар сард Монгол Улсад айлчлал хийхээр төлөвлөж буйтай холбогдуулан Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт зам, тээврийн салбарын чиглэлээр тусгах саналыг газар, хэлтсээс авч нэгтгэн боловсруулж ГХЯ-нд хүргүүлсэн.<br>18.Австралийн Холбооны Улсын Сенатын Ерөнхийлөгч Сьюзан Лаянс тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлал хийх үеийн яриа хэлэлцээний сэдэвт,<br>19. Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В. Путин 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр Улаанбаатар хотноо хоёр талын уулзалт хийх гэж байгаатай холбогдуулан уулзалтын ярианы сэдэвт,<br>20. Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Улаанбаатар хотноо хоёр талын өндөр дээд түвшний уулзалт болох гэж байгаатай холбогдуулан хоёр талын уулзалт хийх гэж байгаатай холбогдуулан уулзалтын ярианы сэдэвт,<br>21. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсад зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдах Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн болон ажиглагч орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн 23 дугаар өргөтгөсөн хуралдаанд оролцох үеийн яриа, хэлэлцээний сэдэвт,<br>22. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2024 оны 07 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсад хийсэн айлчлалд Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэв, айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд,<br>23. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Ерөнхий захирал Чу Донгиу 2024 оны 07 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэрх ярианы сэдэвт,<br>24. Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук-ын 2024 оны 07 дугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалд Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>25. Монгол Улс, Шведийн Хаант Улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд 2024 онд төлөвлөж буй өндөр, дээд түвшний айлчлалд Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>26. Бүгд Найрамдах Филиппин Улсын Гадаад хэргийн сайд Энрикэ А.Манало 2024 оны 08 дугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалд Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>27. Оманы Султант Улсын Гадаад хэргийн сайд Бадр бин Хамад Аль Бусайди 2024 оны 08 дугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалд Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>28. Швейцарын Холбооны Улсын Ерөнхийлөгч Виола Амхерд 2024 оны 08 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Монгол улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэрх ярианы сэдэв болон айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд,<br>29. Румын Улсын Гадаад хэргийн сайд Луминица Одобеску 2024 оны 08 дугаар сард Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэрх ярианы сэдэвт,<br>30. Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгч Наташа Пирц Мусар 2024 оны 08 дугаар сарын 20- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 23-ны өдрүүдэд Монгол улсад хийсэн төрийн айлчлалын үеэрх ярианы сэдэвт,<br>31. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Дэд дарга Хань Жэн 2024 оны 09 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэрх ярианы сэдэвт,<br>32. Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн урилгаар Австралийн Холбооны Улсын Парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч Сюзан Лаянс 2024 оны 10 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд,<br>33. Япон Улсаас манай улсад хийхээр төлөвлөж байсан дээд хэмжээний айлчлалын үеэрх ярианы сэдэвт,<br>34. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын дээд түвшний айлчлалын үеэр Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>35. Бүгд Найрамдах Лаос Улсын Ерөнхийлөгч Тонглун Сисулит-ийн төрийн айлчлал Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>35.Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд оролцсон тухай илтгэх хуудас, мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд,<br>36. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2024 оны 12 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Саудын Арабын Хант Улсад хийсэн ажлын айлчлалд Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>37. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2024 оны 12 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд Арабын Нэгдсэн Эмират Улсад хийсэн ажлын айлчлалд Монголын талаас баримтлах үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт,<br>38.Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Турк Улсад 2025 оны 01 дүгээр сард хийх төрийн айлчлалын үеэрх яриа хэлэлцээний сэдэвт,<br>40.Монгол Улсын Ерөнхий сайд Л.оюун-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид Швейцарийн Холбооны Улсын Давос хотноо 2025 оны 01 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулах Дэлхийн эдийн | |

151

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | засгийн чуулга уулзалтад оролцох үеийн баримтлах үндсэн чиглэлд санал, | |
| 1.1.4 | Зам, тээврийн хөгжлийн сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын гадаад орнуудад хийх айлчлалын бэлтгэл хангах, албан хаагчид, харьяа байгууллагын удирдлагуудын гадаадад томилолтоор ажиллахтай холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зохион байгуулах. | - | Айлчлал, гадаад томилолтын үйл ажиллагаа зохион байгуулсан тоо | Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын **16** айлчлал зохион байгуулагдсан. Яамны албан хаагчид, харьяа байгууллагын удирдлагуудын гадаадад томилолтоор ажиллуулах **56** тушаал шийдвэр гаргуулсан. | **I-IV улирал:** Яамны удирдлагуудын хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус **16** айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана. Харьяа байгууллагын удирдлага, албан хаагчдын гадаад томилолтын **60** тушаал шийдвэрийг гаргуулж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар бүрэн хангана. (тухай бүр) | <u>Сайд, ТНБД-ийн айлчлал:</u><br>1.Зам, тээврийн хөгжлийн сайдын БНХАУ-ын Хэбэй, Шандун мужуудад 2024 оны 01 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд хийсэн ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан. Илтгэх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүлэв.<br>2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын БНХАУ-ын Бээжин хотноо 2024 оны 01 дүгээр 24-27-ны өдрүүдэд ажилласан ажлын бэлтгэл хангаж ажилласан.<br>3.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 24-нөөс 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад ажилласан ажлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан.<br>4.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд Унгар, Словак улсад улсад хийсэн ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллав. Илтгэх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүлэв.<br>5.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд БНХАУ-ын ШУӨЗО-д хийсэн ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллав. Илтгэх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүлэв.<br>6. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын 2024 оны 07 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд АНУ-д ажилласан ажлын бэлтгэл хангаж ажилласан.<br>7.Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын 2024 оны 07 дугаар сарын 28-наас 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд БНХАУ-ын Хөххотод ажилласан ажлын бэлтгэл хангаж ажилласан.<br>8. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын 2024 оны 09 дүгээр сарын 09-13-ны өдрүүдэд БНСУ-д ажилласан ажлын бэлтгэл бүрэн ханган ажилласан.<br>9. Зам, тээврийн сайдын БНХАУ-д 2024 оны 09 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд "Дэлхийн тогтвортой тээврийн форум" арга хэмжээнд оролцох, ажлын айлчлалын бэлтгэл бүрэн хангаж ажиллав. Илтгэх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүлэв. | |

155

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10.Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Туркменистан Улсад 2024.10.10-13-ны өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Зам, тээврийн сайд, Б.Нямдаваа орж ажиллах бэлтгэл ажлыг хангаж ажиллав.<br>11.Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсад 2024 оны 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн болон ажиглагч орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн 23 дугаар өргөтгөсөн хуралдаанд оролцох Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн айлчлалын бүрэлдэхүүнд Зам, тээврийн сайд, БТГ-ын дарга Б.Артур, ГХАХ-ийн Б.Нямдаваа нар ажиллах бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллав.<br>12.Монгол Улсын Ерөнхий сайд Д.Оюун-Эрдэнийн БНХАУ-ын Шанхай хотод 2024.11.04-07-ны өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд Зам, тээврийн сайд, БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт, ТЗУГ-ын ГХАХ-ийн дарга Б.Нямдаваа нар ажиллах бэлтгэл ажлыг хангаж ажиллав.<br>13. Зам, тээврийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдах "Тээврийн долоо хоног-2024" арга хэмжээнд оролцох, ажлын айлчлалын бэлтгэл бүрэн хангаж ажиллав. Илтгэх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүлэв.<br>14.Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын 2024 оны 11 дүгээр сарын 16-25-ны өдрүүдэд ХБНГУ, Итали улсуудад хийсэн ажлын айлчлалын бэлтгэл ажил, Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 9 дүгээр хуралдаанд оролцох бэлтгэл ажлыг тус тус бүрэн хангаж ажиллав.<br>15.Зам, тээврийн сайдын 2024.12.09-11-ний өдрүүдэд Их Британийн нэгдсэн Хаант Улсад хийх ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллав. | |
| | | | | | | **Нийт 15 айлчлалын бэлтгэл хангаж зохион байгуулсан. /Сайдын айлчлал-9, ТНБД-ын айлчлал-6/** Айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган холбогдох газруудад хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | |

156

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Яамны албан тушаалтан, албан хаагчид, Харьяа байгууллагын удирдлагын гадаад томилолтын 71 тушаал шийдвэрийг гаргуулж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар бүрэн хангаж ажилласан байна. Үүнд: Гадаад улсад зохион байгуулагдсан хурал, зөвлөгөөн, уулзалтад нийт 48 тушаалаар давхардсан тоогоор нийт 93 албан тушаалтан,албан хаагчид, харьяа байгууллагын удирдлага хамруулсан бол Сургалт семинарт 24 тушаалаар давхардсан тоогоор нийт 55 албан хаагчдыг хамруулсан байна. | |
| 1.1.5 | Зам, тээврийн хөгжлийн сайдын БНХАУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэх хангах, зохион байгуулах. | - | Хэрэгжилтийн хувь | 2023 онд төлөвлөсөн айлчлал хойшилсон. | **I-III улирал:** Урилгын дагуу айлчлалын товыг тохирсон байна. Айлчлалаар хийгдэх уулзалтуудын товыг тохирч, ярианы сэдвүүдийг боловсруулж, зохион байгуулсан байна. Айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 1.ЗТХ-ийн сайдын БНХАУ-ын Хэбэй, Шандун мужуудад хийх ажлын айлчлалыг 2024.01.15-19-ний өдрүүдэд зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан. Айлчлалын хүрээнд Хэбэй, Шандун мужуудын зам, тээврийн салбарын бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаатай танилцах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны шилдэг арга туршлага судлах, холбогдох байгууллагуудтай хоёр талын уулзалт хийх, зам, тээврийн салбарын бизнес эрхлэгчдийн уулзалт зохион байгуулж ажиллав. Илгээх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүл, айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажилласан.<br>2. ЗТХ-ийн сайдын БНХАУ-ын ШУӨЗО-нд 2024.03.28-04.02-ны өдрүүдэд хийх ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан. Үүнд: айлчлалын тов тогтох, төлөвлөгөө, хөтөлбөр гаргах чиглэлээр айлын талтай холбогдон ажиллаж, Бизнес форум зохион байгуулах, үйлдвэрлэл технологийн парк үзэж танилцах талаар зохион байгуулж ажилласан. Мөн сайдын уулзалтын ярианы сэдэв, илтгэл танилцуулгыг тус тус монгол хятад хэлээр бэлтгэн ажиллав. Илгээх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүл, айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажилласан.<br>3.Зам, тээврийн сайдын БНХАУ-ын Бээжин хотноо 2024.09.25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Дэлхийн тогтвортой тээврийн форум"-д оролцох үеэр хийх ажлын айлчлалын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан. Айлчлалын хүрээнд "Дэлхийн тогтвортой тээврийн форум"-д оролцох үеэр ОХУ-ын Тээврийн яамны орлогч сайд В.В.Потешкин, БНСВУ-ын Тээврийн сайд Нгуен Ван Танг нартай уулзаж зам, | |

157

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тээврийн салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцов. БНХАУ-ын Тээврийн сайд Ли Шяопэнтэй хоёр талын уулзалт хийж Сайд нар хоёр улсын тээврийн салбарын харилцааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон бөгөөд хараахан шийдэж чадаагүй байгаа, хүлээгдэж буй зарим асуудлын талаар санал солилцож, шинэ боломжийн талаар хэлэлцэв. "Хятадын төмөр замын групп" компанийн ТУЗ-ын дарга Лю Жэнфан, Хятадын төмөр замын инженеринг корпорац (CREC), Хятадын төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний корпорац (CRRC)-ийн удирдлагууд болон "Чайна энержи групп" компанийн удирдлагуудтай тус тус уулзаж хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцов. Илгээх хуудсыг ЗГХЭГ-т хүргүүл, айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажилласан.<br>4. Монгол Улсын Ерөнхий сайд Д.Оюун-эрдэнийн БНХАУ-ын Шанхай хотод 2024.11.04-07-ны өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд Зам, тээврийн сайд, БТГ-ын дарга Б.Артур, ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт, ТЗУГ-ын ГХАХ-ийн дарга Б.Нямдаваа нар ажиллах бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлсэн. | |
| 1.1.6 | ХБНГУ-ын Цахим хөгжил, тээврийн сайд Фолкер Виссингийн Монгол Улсад хийх айлчлалын бэлтгэл хангах, зохион байгуулах. | - | Хэрэгжилтийн хувь | Монголын талаас уг айлчлалыг 2024 оны 03 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд зохион байгуулах саналыг дэмжиж байгаа тухай санал хүргүүлсэн. | **I-II улирал:**<br>Айлчлалын бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг **100%** хангаж ажиллана.<br>Албан ёсны урилгыг хүргүүлсэн байна.<br>Айлчлалын үеэр байгуулах баримт бичгүүдийн төслийг тохирсон байна.<br>Яамны удирдлагуудтай хийх уулзалтын ярианы сэдвийг боловсруулсан байна.<br>Айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга | Зам, тээврийн хөгжлийн сайдын урилгаар ХБНГУ-ын Холбооны Цахим хөгжил, тээврийн сайд, Бундестагийн гишүүн, ноён Др. Фолькер Виссингийн 2024 оны 03 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд Монгол Улсад хийх албан ёсны айлчлалын бэлтгэл ажлын бүрэн хангаж ХБНГУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран ажиллав.<br>Айлчлалын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>**1**. Айлчлалын бүрэлдэхүүнийг нисэх онгоцны буудал дээр угтах, үдэх, тусгай үүргийн онгоц буулгахтай холбоотой зохион байгуулалтын асуудал, онгоц байршуулах ангарын асуудал шийдвэрлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br>**2**.Яам хоорондын албан ёсны уулзалтыг 2024.03.05-ны өдрийн 14:00-15:00 цагт ЗТХЯаманд, 15.30-17.30 цагт Төрийн ордны жанжин Д.Сүхбаатар танхимд "Өргөтгөсөн уулзалт", санамж бичиг зурах ёслол, хэвлэлийн бага хурал зэрэг арга хэмжээг зохион | |

158

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | байгуулсан.Зохион байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдийг ордонд оруулах, угтах, үдэх ёслолын ажил, ярианы сэдэв, танилцуулга бэлтгэн, гарын үсэг зурах санамж бичиг ГХЯ-аар хянуулж бэлэн болгох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн хэвлэлийн бага хурал зохион байгуулж хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр шууд дамжуулалтыг дамжуулж, мэдээ мэдээлэл түгээн ажиллав.<br>**3.**2024.03.06-ны өдрийн Монгол-Германы бизнесийн дугуй ширээний уулзалтыг ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран ГХЯ-ны "Зөвшилцөл" танхимд зохион байгуулав. Уг дугуй ширээний уулзалтад төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын дотоод, гадаадын 50 гаруй төлөөлөл оролцож, зам, тээврийн салбарын өнөөгийн байдал, бодлого чиглэлийг танилцуулж, хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгө оруулалтын боломж, туршлагийн талаар санал солилцож, хэлэлцэв.<br>**4.**ХБНГУ-ын Холбооны Цахим хөгжил, тээврийн Сайдын Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-эрдэнэтэй уулзах уулзалтад ярианы сэдэвт санал, Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б. Дэлгэрсайхан нартай хийх уулзалт зохион байгуулахтай холбоотой ажил, машинаар үйлчлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.<br>**5.**Бусад зохион байгуулалттай холбоотой зохион байгуулалтыг бүрэн хангаж ажиллав. | |
| 1.1.7 | Зам, тээврийн хөгжлийн сайдын БНСВУ-д хийх ажлын айлчлалын бэлтгэх хангах, зохион байгуулах. | - | Хэрэгжилтийн хувь | 2023 оны төлөвлөгөөнд туссан ч хойшлогдсон. | **I-III улирал:**<br>Урилгын дагуу айлчлалын товыг тохирсон байна.<br>Айлчлалын бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг **100%** хангаж ажиллана.<br>Айлчлалаар хийгдэх уулзалтуудын товыг тохирч, ярианы | Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад дээд түвшинд айлчлал хийсэн. Айлчлалын бүрэлдэхүүнд тус улсын Тээврийн сайд Нгуен Ван танг Монгол Улсад ирсэн тул Монгол Улсын Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсын тээврийн сайд Нгуен Ван Тангийг хүлээн авч уулзан хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, агаарын тээвэр, хуурай боомтын талаар харилцан туршлага судлах, хөрөнгө оруулах чиглэлд хамтран | |

159

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдвүүдийг боловсруулсан байна. Айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | ажиллах боломжуудын талаар санал солилцож, хоёр яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт 2024.09.30-ны өдөр гарын үсэг зурсан. Уг санамж бичиг байгуулах, хоёр талт уулзалтын бэлтгэл ажлыг хангаж ажиллаж, санамж бичигт гарын үсэг зурах ёслол зохион байгуулав. | |
